



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 94

Улаанбаатар хот

Хөрөнгө акталж данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хотын стандарт хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болох нь нотлогдсон 11 нэрийн, нийт 568,012,805.82 (таван зуун жаран найман сая арван хоёр мянга найман зуун таван төгрөг наян хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ, 451,250,123.03 (дөрвөн зуун тавин нэгэн сая хоёр зуун тавин мянга нэг зуун хорин гурван төгрөг гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Акталж данснаас хасах хөрөнгөөс авч ашиглаж болох хөрөнгийг ялган сонгон шалгаруулалтаар худалдан борлуулах, ашиглах боломжгүй хөрөнгийг хоёрдогч түүхий эд, сэлбэгийн зориулалтаар ашиглах, худалдах, орлогыг Улсын төсөвт төвлөрүүлэх;

2.4.Хөрөнгө акталж, хэсэгчлэн чөлөөлөгдсөн газрыг төрийн байгууллагын эзэмшилд хэвээр үлдээж, зориулалтыг өөрчлөх, дахин төлөвлөлт хийх, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах;

2.5.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.6.Арга хэмжээний биелэлтийн хамт 2024 оны 2 дугаар улиралд багтаан тайлагнах.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

 Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2024 оны ... дугаар сарын ... өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Талбайн хэмжээ, үзүүлэлт	Балансын нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
				(төгрөг)		
1	Аж ахуйн контор	9/1/1997	191.4 мкв	45,398,516.55	15,168,404.69	30,230,111.86
2	Лабораторын байр	10/1/1996	228.09 мкв	51,486,185.48	17,100,563.31	34,385,622.17
3	Насосны барилга	4/1/1996	82.46 мкв	13,087,638.90	4,507,525.53	8,580,113.37
4	Хуучин контор /няравын/	10/1/1996	40.12 мкв	2,526,548.98	2,319,458.31	207,090.67
5	Саравч -Шатахууны саравч	1/8/2004		2,692,800.00	1,456,739.01	1,236,060.99
6	Ууршуулах болон лагын талбай	9/30/2010	789.4 мкв	27,376,392.00	7,805,576.54	19,570,815.46
7	Усан сан 500м куб	12/31/2006	500 м.куб	80,000,000.00	73,261,428.97	6,738,571.03
8	Гадна халаалт цэвэр усны шугам	11/1/2006	340м	40,000,000.00	33,041,492.70	6,958,507.30
9	Гадна халаалт цэвэр усны шугам	12/12/2006	170м	49,284,200.00	40,428,410.06	8,855,789.94
10	1000 м.куб багтаамжтай шатахуун хадгалах ил сав	11/1/1998	1000 м.куб	132,602,088.87	132,602,088.87	-
11	1000 м куб сав ил - шатахууны сав	11/1/1998	1000 м.куб	123,558,435.04	123,558,435.04	-
Нийт дүн				568,012,805.82	451,250,123.03	116,762,682.79
				(таван зуун жаран найман сая арван хоёр мянга найман зуун таван төгрөг наян хоёр мөнгө)	(дөрвөн зуун тавин нэгэн сая хоёр зуун тавин мянга нэг зуун хорин гурван төгрөг гурван мөнгө)	(нэг зуун арван зургаан сая долоон зуун жаран хоёр мянга зургаан зуун наян хоёр төгрөг далан есөн мөнгө)